



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/85/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Д.Цэцэгмаа Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaa_1961@yahoo.com Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Агуулга

1.Аудитын гэрчилгээ /эх хувь	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6.Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт.....	17
4.1. Зөвлөмж.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101

Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.24 № 2178

БАЯНХОНГОР АЙМГИЙН
ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
М.ДОРЖДАГВА ТАНАА

танай _____ -ны № _____ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\alban bichig\A4-toot.docx

005020411

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

A handwritten signature in black ink is written over a red official stamp. The stamp is rectangular and contains a central emblem with a flame-like symbol. The text 'ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР' is printed on the left side of the stamp, and 'Б.МӨНХБАТ' is printed on the right side. The signature is a large, stylized cursive script.

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>63,935,991.00</u>	<u>233,573,117.26</u>
33	АВЛАГА	00.00	154,128,015.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	26,053.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	154,020,000.00
335	Бусад авлага	00.00	81,962.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	81,962.00
35	БАРАА МАТЕРИАЛ	63,935,991.00	79,445,102.26
351	Түүхий эд материал	26,587,751.00	39,112,732.26
35110	Тусгай зориулалттай материал	26,587,751.00	30,853,618.06
35130	Эм боох материал	00.00	8,259,114.20
354	Хангамжийн материал	37,348,240.00	40,332,370.00
35410	Бичиг хэргийн материал	877,550.00	974,600.00
35420	Аж ахуйн материал	35,141,540.00	38,703,840.00
35440	Түлш, шатах тослох материал	800,000.00	00.00
35460	Хүнсний материал	529,150.00	653,930.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>140,924,238.85</u>	<u>152,628,556.85</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	140,924,238.85	152,628,556.85
392	Биет хөрөнгө	129,310,238.85	141,014,556.85
39201	Барилга, байгууламж, орон сууц	89,032,377.00	89,032,377.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-30,977,043.36	-46,465,565.04
39203	Авто-тээврийн хэрэгсэл	66,140,000.00	66,140,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-24,936,944.41	-36,513,611.05
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	127,308,379.27	177,652,029.73
39206	Хуримтлагдсан элэгдэл	-103,682,232.58	-114,120,424.21
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,974,086.50	17,974,086.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,772,383.57	-13,208,336.08
39217	Ном	224,000.00	524,000.00
393	Биет бус хөрөнгө	11,614,000.00	11,614,000.00
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	11,614,000.00	11,614,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>204,860,229.85</u>	<u>386,201,674.11</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>176,610.00</u>	<u>14,191,147.20</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	176,610.00	14,191,147.20
413	Өглөг	176,610.00	14,191,147.20
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	176,610.00	892,137.00

Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	8,142,910.20
4136	Бусад өглөг	00.00	5,156,100.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	5,156,100.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	204,683,619.85	372,010,526.91
51	Засгийн газрын хувь оролцоо	204,683,619.85	372,010,526.91
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	175,490,678.27	175,490,678.27
51101	Өмч: - төрийн	175,490,678.27	175,490,678.27
512	Хуримтлагдсан үр дүн	-98,577,634.31	68,749,272.75
51210	Өмнөх үеийн үр дүн	-98,577,634.31	-98,577,634.31
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	167,326,907.06
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	127,770,575.89	127,770,575.89
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	204,860,229.85	386,201,674.11

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	453,605,076.00	776,414,213.02
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	48,578,602.00	72,904,378.02
120	Нийтлэг татварын бус орлого	48,578,602.00	72,904,378.02
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	48,578,602.00	72,904,378.02
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	48,578,602.00	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого ҮХ		41,893,650.46
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого БМ		31,010,727.56
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	405,026,474.00	703,509,835.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	345,117,400.00	395,772,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	345,117,400.00	395,772,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,224,734.00	271,415,240.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,060,334.00	56,905,240.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	164,400.00	00.00
131107	нэмэлт		60,490,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	20,939,400.00	18,380,755.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,939,400.00	18,380,755.00

Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	17,744,940.00	17,941,040.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	17,744,940.00	17,941,040.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	441,243,116.46	609,087,305.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	441,243,116.46	609,087,305.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	429,177,527.46	599,901,071.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	274,256,065.00	306,364,299.00
210101	Үндсэн цалин	192,229,358.00	261,557,724.00
210102	Нэмэгдэл	58,083,633.00	38,391,628.00
210104	Урамшуулал	23,943,074.00	6,414,947.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,320,261.00	40,915,632.00
210201	Тэтгэврийн даатгал	24,427,849.00	28,925,804.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,914,765.00	3,231,710.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,241,092.00	2,442,640.00
210204	Ажилгүйдлийн даатгал	519,271.00	574,133.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,217,284.00	5,741,345.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,328,729.00	18,000,755.00
210301	Гэрэл, цахилгаан	2,627,229.00	2,199,155.00
210302	Түлш, халаалт	14,701,500.00	15,801,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,487,793.00	69,320,322.50
210401	Бичиг хэрэг	2,349,980.00	2,411,550.00
210402	Тээвэр, шатахуун	14,499,600.00	19,501,930.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,472,913.00	1,521,676.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,699,600.00	7,871,050.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	465,700.00	38,014,116.50
2105	Нормативт зардал	25,051,773.40	69,053,052.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,654,133.00	48,036,082.00
210502	Хоол, хүнс	7,404,640.40	19,826,970.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	993,000.00	1,190,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,877,937.00	1,576,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	103,087.00	00.00
210604	Урсгал засвар	4,774,850.00	1,576,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,424,000.00	1,450,000.00
210702	Дотоод албан томилолт	2,424,000.00	1,450,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,787,465.00	47,717,799.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	937,465.00	47,267,799.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	850,000.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,643,504.06	45,503,212.46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,339,028.00	6,563,880.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,304,476.06	38,939,332.46

Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,065,589.00	9,186,234.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,035,334.00	8,562,438.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	12,035,334.00	8,562,438.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	16,171.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,171.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,084.00	623,796.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,084.00	623,796.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>12,361,959.54</u>	<u>167,326,907.06</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>12,361,959.54</u>	<u>167,326,907.06</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>405,026,474.00</u>	<u>549,489,835.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>405,026,474.00</u>	<u>549,489,835.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	345,117,400.00	395,772,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	345,117,400.00	395,772,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21,224,734.00	117,395,240.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,060,334.00	56,905,240.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	164,400.00	00.00
131107	нэмэлт		60,490,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	20,939,400.00	18,380,755.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,939,400.00	18,380,755.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	17,744,940.00	17,941,040.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	17,744,940.00	17,941,040.00

Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	405,026,474.00	544,739,835.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	405,026,474.00	544,739,835.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	392,960,885.00	516,485,799.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	269,438,299.00	305,365,060.00
210101	Үндсэн цалин	182,517,099.54	183,735,840.00
210102	Нэмэгдэл	68,642,487.46	88,383,560.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	5,696,000.00
210104	Урамшуулал	18,278,712.00	27,549,660.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,679,900.00	41,225,397.00
210201	Тэтгэврийн даатгал	22,902,300.00	29,010,499.48
210202	Тэтгэмжийн даатгал	2,694,400.00	3,053,699.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,155,500.00	2,442,999.59
210204	Ажилгүйдлийн даатгал	538,900.00	610,699.62
210205	Эрүүл мэндийн даатгал	5,388,800.00	6,107,499.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,328,729.00	17,880,755.00
210301	Гэрэл, цахилгаан	2,627,229.00	2,199,155.00
210302	Түлш, халаалт	14,701,500.00	15,681,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,663,100.00	25,587,207.00
210401	Бичиг хэрэг	1,197,500.00	1,200,000.00
210402	Тээвэр, шатахуун	14,499,600.00	17,265,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,016,000.00	1,671,676.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	4,499,931.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	950,000.00	950,000.00
2105	Нормативт зардал	22,678,100.00	26,205,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,478,100.00	17,945,000.00
210502	Хоол, хүнс	5,750,000.00	5,750,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,450,000.00	2,510,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,844,500.00	2,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,250,000.00	00.00
210604	Урсгал засвар	3,594,500.00	2,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,474,000.00	1,450,000.00
210702	Дотоод албан томилолт	1,474,000.00	1,450,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,532,465.00	90,215,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,682,465.00	89,765,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	850,000.00	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,321,792.00	6,557,380.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,321,792.00	6,557,380.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,065,589.00	28,254,036.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,035,334.00	27,630,240.00

Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	12,035,334.00	27,630,240.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	16,171.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,171.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,084.00	623,796.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,084.00	623,796.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	4,750,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	4,750,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	4,750,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	4,750,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	4,750,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-4,750,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А						
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН						
/ төгрөгөөр /						
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	175.490.678.27	127.770.575.89	-110.939.593.85	00.00	192.321.660.31
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	175.490.678.27	127.770.575.89	-110.939.593.85	00.00	192.321.660.31
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	12.361.959.54	00.00	12.361.959.54
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	175.490.678.27	127.770.575.89	-98.577.634.31	00.00	204.683.619.85
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	175.490.678.27	127.770.575.89	-98.577.634.31	00.00	204.683.619.85
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	175.490.678.27	127.770.575.89	-98.577.634.31	00.00	204.683.619.85
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	167.326.907.06	00.00	167.326.907.06
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	175.490.678.27	127.770.575.89	68.749.272.75	00.00	372.010.526.91

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	438.148.400.00	431.470.799.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	438.148.400.00	431.470.799.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	438.148.400.00	431.470.799.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	305.373.100.00	305.365.060.00
210101	Үндсэн цалин	183.718.300.00	183.735.840.00
210102	Нэмэгдэл	89.015.100.00	88.383.560.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5.082.000.00	5.696.000.00
210104	Урамшуулал	27.557.700.00	27.549.660.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41.225.400.00	41.225.397.00
210201	Тэтгэврийн даатгал	29.010.500.00	29.010.499.48
210202	Тэтгэмжийн даатгал	3.053.700.00	3.053.699.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	2.443.000.00	2.442.999.59
210204	Ажилгүйдлийн даатгал	610.700.00	610.699.62
210205	Эрүүл мэндийн даатгал	6.107.500.00	6.107.499.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24.119.400.00	17.880.755.00
210301	Гэрэл, цахилгаан	3.043.400.00	2.199.155.00
210302	Түлш, халаалт	20.676.000.00	15.681.600.00
210303	Цэвэр, бохир ус	400.000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26.231.600.00	25.887.207.00
210401	Бичиг хэрэг	1.200.000.00	1.200.000.00
210402	Тээвэр, шатахуун	17.265.600.00	17.265.600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2.016.000.00	1.671.676.00
210404	Ном, хэвлэл	300.000.00	300.000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4.500.000.00	4.499.931.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	950.000.00	950.000.00
2105	Нормативт зардал	26.205.000.00	26.205.000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17.945.000.00	17.945.000.00
210502	Хоол, хүнс	5.750.000.00	5.750.000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2.510.000.00	2.510.000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6.450.000.00	6.450.000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4.450.000.00	4.450.000.00
210604	Урсгал засвар	2.000.000.00	2.000.000.00
2107	Томилолт, зочны зардал	1.457.300.00	1.450.000.00
210702	Дотоод албан томилолт	1.457.300.00	1.450.000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	450.000.00	450.000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450.000.00	450.000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6636600.00	6557380.00

Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6.636.600.00	6.557.380.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	438.148.400.00	431.470.799.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	395.772.800.00	395.333.844.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	395.772.800.00	395.333.844.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	24.619.400.00	18.380.755.00
132001	Орон нутгийн төсвөөс	24.619.400.00	18.380.755.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	17.756.200.00	17.756.200.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	17.756.200.00	17.756.200.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23	23
620001	Удирдах ажилтан	01	01
620002	Гүйцэтгэх ажилтан	16	16
620003	Үйлчлэх ажилтан	06	06

2.6. Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	21.224.734.00	117.395.240.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	21.224.734.00	117.395.240.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21.224.734.00	89.765.000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		89.765.000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		89.765.000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21.224.734.00	27.630.240.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21.224.734.00	27.630.240.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	21.224.734.00	27.630.240.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	21.224.734.00	117.395.240.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	21.224.734.00	117.395.240.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21.060.334.00	56.905.240.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	164.400.00	00.00
131107	Төсвийн байгууллагын нэмэлт орлого	0.00	60.490.000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын

талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газартай хийсэн гэрээний үндсэн дээр "Глобал капитал аудит" ХХК-ийн аудитор Д.Цэцэгмаа гүйцэтгэж, чанарын хяналтыг Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Санхүүгийн тайлант хугацаанд Эрүүл мэндийн төвийн эрхлэгч М.Дорждавга нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч Б.Мэндбаяр нар хоёрдугаар гарын үсгийг тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хүрээмарал сумын ЭМТ нь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг жигд сайжруулж, хүн амд эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх, эмчилгээ оношилгооны орчин үеийн аргыг нэвтрүүлснээр хүн амын эрүүл мэндийг сайжруулах, хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, аюулгүй, тэгш хүртээмжтэй үзүүлэх зорилтыг дэвшүүлэн ажилласан байна

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 42 тоот тушаалаар батлагдсан салбарын хэмжээнд мөрдөж байгууллагын өөрийн онцлогт нийцүүлэн боловсруулж холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг ашиглаж байна.

Тус байгууллага нь дотоод аудитын албан байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь хэрэгжүүлдэг ба Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 441,243.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,618.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,963.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 6,852.2 мянган төгрөг буюу 1,888.2 мянган төгрөгөөр өссөн байгаа нь Ковид -19 цар тахалтай холбоотой нэмэлт санхүүжилтийн дансаар ЭМД-ын санхүүжилтийн 117,395.2 мянган төгрөгийн орлого төвлөрч зарцуулагдсан, ЭМДС-гийн дутуу санхүүжилтийн 154,020.0 мянган төгрөгийг үр дүнгийн тайланг орлогоор хүлээн зөвшөөрч авлага үүссэнтэй холбоотой тул өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 386,201.7 мянган төгрөг болж өмнөх оноос 181,341.4 мянган төгрөгөөр буюу 46,9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, авлага үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	63.936.0	233.573.1	169.637.1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	154.128.0	154.128.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	63.936.0	79.445.1	15.509.1
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	140.924.2	152.628.6	11.704.3
Үндсэн хөрөнгө	312.742.8	363.386.5	50.643.7
Хуримтлагдсан элэгдэл	(171.818.6)	(210.757.9)	(38.939.3)
Нийт хөрөнгө	204.860.2	386.201.7	181.341.4
Өр төлбөр	176.6	14.191.1	14.014.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	204.683.6	372.010.5	167.326.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	204.860.2	386.201.7	181.341.4

Эх сурвалж: 2021 оны санхүүгийн тайлангаас

Бараа материалын дансны үлдэгдэл 79,445.1 мянган төгрөг болж 15,509.1 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 4,265.9 мянган төгрөгөөр, эм боох материалын дансны үлдэгдэл 8,259.1 мянган төгрөг, аж ахуйн материал 3,562.3 мянган төгрөг болж тус тус өссөн нь голлох нөлөөг үзүүлж

байна. Энэ нь Ковид -19 цар тахалтай холбоотой хамгаалах хэрэгсэл, эмийн нөөцийг нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрээр бэлтгэсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 154,128.0 мянган төгрөг болж өмнөх оноос өссөн нь ЭМДС-гаас авах Ковид-19 өвчлөлийн эмчилгээний төлбөрийн санхүүжилт орж ирээгүйтэй холбоотой ба авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан.

Өглөг данс 14,014.5 мянган төгрөгөөр өссөн нь ЭМДС-ийн дутуу санхүүжилтээс шалтгаалж ажил үүссэн ба үүнээс 5,971.0 мянган төгрөг нь эмийн, 1,436.3 мянган төгрөг нь тээвэр, шатахууны, 615.6 мянган төгрөгийн хоолны зардлын өглөг шинээр үүссэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 363,386.5 мянган төгрөг болж 11,704.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 4,450.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 300.0 мянган төгрөгөөр ном худалдан авч, ЭМЯ-наас 41,893.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй нийлүүлэгдэж, Ай МЕД ТЕХНОЛОЖИ компаниас 4,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг хандиваар хүлээн авснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 372,010.5 мянган төгрөг болж 167,326.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Эрүүл мэндийн системийн байгууллагууд төсвийн төлөвлөлтийг хийхдээ цалингийн зардал, тогтмол зардлын төсвийг төлөвлөж, бусад суурь үзүүлэлтийг ЭМГ-т хүргүүлдэг ба системийн дээд байгууллага нь нэг иргэнээр тооцсон хувьсах зардлын нормативыг баримтлан тухайн сумын хүн амын тоотой харьцуулж төсвийг төлөвлөдөг ба тайлант онд 438,148.4 мянган төгрөгийг зарцуулах төсөв батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 438,148.4 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 395,772.8 мянга, орон нутгийн төсвөөс 24,619.4 мянга, ЭМДС-гаас 17,756.2 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 395,772.8 мянга, орон нутгийн төсвөөс 18,380.7 мянга, ЭМД-аас 17,941.0 мянга, нийт 432,094.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 431,470.8 мянган төгрөгийг зарцуулсан ба 623.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, орон нутгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 6,238.6 мянган төгрөгөөр дутуу авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 431,470.8 мянган төгрөг буюу 98,5 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 6,238.6 мянган төгрөгөөр хэмнэснээс шалтгаалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн

тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 117,395.2 мянган төгрөгийн орлого төвлөрч зарцуулагдсан байна. Нийт төвлөрсөн орлогын 60,490.0 мянган төгрөг нь Ковид-19 цар тахлын эмчилгээний төлбөрөөс орсон орлого байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа ЭМЯ,улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор ажилласан.

Эрүүл мэндийн төвийн хүрээнд эмнэлгийн мэргэжилтнүүд өвчтөн болон үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг зохицуулах зорилгоор хэвтэн эмчлүүлэгчдийг зөв ялган таних бугуйвчийг ашиглаж ажилласан байна.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Баян ташаагийн эх аудит” ХХК-ийн аудитор Ч.Чимгээ санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Тайлант онд 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 438.1сая төгрөгийн төсөв батлагдсан ба гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 94.0%-ийн биелэлттэй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 609,087.3 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 167,844.2 мянган төгрөгөөр буюу 38,1 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь нормативд зардал 44,001.2 мянга , бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардал 45,930.3 мянган төгрөгөөр өссөн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийн сайтад оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл , мэдээлбэл зохих 149 мэдээллээс тухай бүр мэдээлэх хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн

17,945.0 мянган төгрөгийн 1 мэдээлэл, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаягийн 32,441.2 мянган төгрөгийн 1, нийт 50,386.2 мянган төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа нь тусгай чиг үүрэг бүхий байгууллага тул дээрх тогтоолд хамаарахгүй болно.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 17,265.0 мянган төгрөгийн шатах тослох материал худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулах тендерийг сумын ЗДТГ зохион байгуулж “Баянбат мандал” ХХК-тай гэрээ байгуулсан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар Зөрчилгүй санал дүгнэлт авсан ба илэрсэн зөрчлийг дахин давтахгүй байх 2 заалт бүхий зөвлөмж өгсний хэрэгжилтийг 2021.05.31–ний №46 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант хугацаанд ЭМД-аас авах санхүүжилтийн 154,020.0 мянган төгрөгийн авлага үүссэн ба цаашид өглөг авлагын тооцоог тухайн онд нь багтаан шийдвэрлэхэд анхаарч ажиллах шаардлагатай.

Мөн аймгийн ЭМГ-аас олгосон тендерийн эмийн орлого 101.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байгааг тооцоо нийлж баталгаажуулан өр авлагыг барагдуулсан эсэхэд анхаарал хандуулах шаардлагатай

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 1 заалт бүхий зөвлөмж өгөв.

4.1. Зөвлөмж

4.1.1 Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийн сайтад оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, мэдээлбэл зохих 149 мэдээллээс 50,386.2 мянган төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.6.хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж, сонгон шалгаруулсан бол шалгаруулалтын ерөнхий мэдээлэл, 6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хуулийн цаглаварт хугацаанд мэдээллийг бүрэн, үнэн зөв мэдээлж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

_____оОо_____